

**ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН
НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН
ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал:

**Нэг.Монгол Улсын Их Хурлын чуулгын хуралдааны дэгийн тухай хуулийн
42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгасан санал:**

1.Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн “орон нутгийн байгууллага,” гэсний дараа “хамтарсан баг” гэж нэмэх.

Санал гаргасан:Нийгмийн бодлогын байнгын хороо

**Хоёр.Монгол Улсын Их Хурлын чуулгын хуралдааны дэгийн тухай хуулийн
42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтын дагуу хураалгасан санал:**

1.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.13 дахь заалтын, 36 дугаар зүйлийн 36.2.4 дэх заалтын “тохиолдлын зохицуулалт” гэснийг, мөн зүйлийн 36.2.5 дахь заалтын “тохиолдол” гэснийг тус тус хасах.

Санал гаргасан:Нийгмийн бодлогын байнгын хороо

2.Төслийн 25 дугаар зүйлийн 4 дэх тайлбарыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“Энэ зүйлд заасан “цахимаар дарамтлах” гэж хүний хувийн болон эмзэг мэдээллийг ашиглан цахим орчинд хүүхдэд түгшүүр төрүүлэх, шахалт үзүүлэх үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.”

Санал гаргасан:Нийгмийн бодлогын байнгын хороо

---o0o---